



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ**

2011 оны 09 сарын 14 өдөр

Дугаар 343

Улаанбаатар хот

**Сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулах,
хамгаалалтын зардал олгох тухай**

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 177 дугаар тогтоолоор баталсан, “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар ОХУ-ын Дотоод явдлын яамны харьяа Москвагийн их сургуулийн адъюнктурт суралцаж байгаа Юндэндоржийн Бадамхандын 1 жилийн сургалтын төлбөр, Улсын Их Хурлын захиалгаар ОХУ-ын Буриадын улсын их сургуульд эрдмийн зэрэг хамгаалах Дагвадоржийн Очирбат, Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар ОХУ-ын Төрийн албаны академид эрдмийн зэрэг хамгаалах Ванчигийн Удвал, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны захиалгаар ОХУ-ын Шинжлэх ухааны академийн Монгол судлал, буддын судлал, төвд судлалын хүрээлэнгийн Сибирийн салбарт эрдмийн зэрэг хамгаалах Дэмбэрэлийн Энхбаяр нарын эрдэм шинжилгээний ажлын хамгаалалтын зардлыг Сургалтын төрийн сангаас санхүүжүүлсүгэй.

2. Суралцагчтай гэрээ байгуулж, төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД



Ё.ОТГОНБАЯР